# *МАЛ АЖ АХУЙН НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ОНЦЛОГ*

***Гүйцэтгэсэн: Б.Бигэрмаа /ХААИС-ЭЗБС НББ IV анги/***

***Холбоо барих утас: 99980259***

***Улаанбаатар хот***

***2017 он***

***Үндэслэл***

Манай улс 1990 онд төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн тогтолцооноос зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр аж ахуйн нэгж, байгууллагууд дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн бүртгэл тайлангийн шинэ эрх зүйн орчинг бүрдүүлэх шаардлагаар 1993 онд баталсан "Нягтлан бодох бүртгэлийн тухай" хуулиндаа "Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартыг" хэрэгжүүлэхээр заасан билээ. Энэхүү хуулийн хүрээнд ААН-үүд практикт НББОУС-ыг тодорхой түвшинд ашиглаж байгаа ч хөдөө аж ахуйн үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжүүдийн хувьд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн боловсруулсан байдал хангалтгүй, ХАА-н байгууллагуудын санхүүгийн тайлан дахь Биологийн хөрөнгө, ХАА-н бүтээгдэхүүний ангилал, хэмжилт, хүлээн зөвшөөрөлт, үнэлгээний суурь, арга хандлага, толилуулга, тодруулгын байдал нь СТОУС-д бүрэн нийцээгүй байгаа тул биологийн хөрөнгө болон мал аж ахуйн бүтээгдэхүүнийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгэх, НББОУС 41-ын практик хэрэглээг нэмэгдүүлэхийг шаардаж байна.

***Зорилго***

МАА-н бүтээгдэхүүнийг НББ-д хэрхэн тусгах, тайлагнах онол арга зүйг судалж, биологийн хөрөнгө болон МАА-н бүтээгдэхүүний бодит үнэ цэнийг тодорхойлж улмаар практик хэрэглээг нэмэгдүүлж болох арга замыг тодорхойлоход судалгааны зорилго оршино.

**"Хишигтэн нүүдэлчин" ХХК-ийн биологийн хөрөнгө ба МАА-н бүтээгдэхүүнийг НББОУС-ын дагуу бүртгэж, тайлагнасан үр дүн**

Компани биологийн хөрөнгийн анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнийн тооцооллыг хийхдээ зах зээлийн бодит үнэ цэнийн мэдээлэлд бус компанийн дотоод мэдээлэлд суурилдаг байна. Жишээлбэл, тайлангийн жилд төрсөн тугалыг өмнөх тайлант жилд тогтоосон төлийн үнээр орлогод авсан байна. Мөн ХАА-н бүтээгдэхүүн болох сүүг хүлээн зөвшөөрөхдөө зах зээлийн үнээр авсан хэдий ч сүүг борлуулахтай холбоотой гардаг борлуулалтын зардлыг хасаагүй дүнгээр хүлээн зөвшөөрч, жилийн эцэст бэлэн байгаа биологийн хөрөнгөд БҮЦ-ийн тооцоолол хийгээгүйгээс компанийн биологийн хөрөнгийн өртөг БҮЦ-ээс өндрөөр тогтоогдсон байх магадлалтай. Иймд биологийн хөрөнгийн БҮЦ-ийг зах зээлийн бодит мэдээлэлд суурилан тооцоолж залруулга хийх шаардлагатай.

## 1. Сүүг анх борлуулах зардлыг хассан БҮЦ-ээр нь бүртгэх

| | |
|---|---|
| ***Сүү хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэний олз-Бүртгэл*** | ***1,173,031,398.60*** |
| **Сүүний зах зээлийн үнэ /БҮЦ/** | **1,135,831,520.00** |
| Борлуулалт, маркетингийн зардал | **(44,311,051.80)** |
| Цалин борлуулалт | **(13,235,780.00)** |
| НДШ-Борлуулалт | **(1,603,011.60)** |
| ***Сүү борлуулалтын зардал*** | **(59,149,843.40)** |
| **Сүү хүлээн зөвшөөрөлтийн дүн** | **1,076,681,676.60** |

Тус компанийн үндсэн бүтээгдэхүүн сүү нь үйлдвэрлэгдсэн даруйдаа борлуулагддаг тул үйлдвэрлэлийн зардлыг ДҮ, ҮНЗХ дансанд ангилан хуримтлуулж бүртгэхгүйгээр шууд борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээснээр бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн зардлыг зөв ангилах, зардал өртгийн тухай мэдээллээр удирдлагыг хангах, зардлыг бодитойгоор төлөвлөж, түүгээр дамжуулан гүйцэтгэлд нь хяналт тавьж чадахгүйд хүргэж байна. Иймд сүүтэй холбоотой гарсан бүх зардлыг ДҮ, ҮНЗХ дансанд хуримтлуулан бүртгэж уг дүн болон сүүний борлуулах зардал хассан бодит үнэ цэнийн зөрүүд сүү хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг бүртгэе.

**“Хишигтэн нүүдэлчин” ХХК үйлдвэрлэлийн зардлыг ангилах нь**

| ***Үйлдвэрлэлийн зардлын ангилал*** | ***“Хишигтэн нүүдэлчин” ХХК-ын зардлыг ангилсан байдал*** |
|---|---|
| Шууд материалын зардал | Тэжээлийн зардал бөгөөд зөвхөн саалийн үнээ, дөнж, гунжид өгсөн байгалийн ба таримал өвс, тэжээлийн улаанбуудай, арвай, овъёос, хивэг, хужир, дарш, хэвтрийн солом, вандуй, байгалийн шохой гэх мэт тэжээлийн зардал орно. |
| Шууд хөдөлмөрийн зардал | Саальчин /операторч/, тэжээлийн технологичийн үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл орно. |
| Үйлдвэрлэлийн нэмэгдэл зардал | Шууд бус материалын зардал: Эмчилгээний материал, хангамжийн материал, ариутгал цэвэрлэгээний бодис, шатах тослох материал, хөдөлмөр хамгаалал, аж ахуйн зардал, цахилгаан дулааны зардал, сангийн зардал, сэлбэг хэрэгсэл, худаг, бусад үйл ажиллагаатай холбоотой зардал орно. |
| | Шууд бус хөдөлмөрийн зардал: Малзүйч, малын эмч, сүүний технологич, санитар, туслах ажилтан, гэрээт ажилтан, засварчин, тогоочийн үндсэн болон нэмэгдэл цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл, ажилчдын хоолны зардал, гар утасны хэрэглээний зардал зэрэг зардлууд орно. |
| | Бусад шууд бус зардал: Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал, даатгалын зардал, гадны байгууллагын хөлс, газрын төлбөр, малын татвар, нүүрсний зардал, автомашины түрээсийн зардал, өвчнөөр хорогдсон малын зардал (малын эмчийн актаар), засвар үйлчилгээ, шинжилгээний зардал, /борлуулалт, удирдлагын ажилчдаас бусад/ байгууллага хариуцан төлдөг НДШ, ЭМДШ-ийн зардал, урсгал засварын зардал зэрэг багтана. |

**Үйлдвэрлэлийн зардлын урсгал**

**ШМЗ**

- Тэжээлийн зардал /саалийн чиглэлийн үхэр/

**ШХЗ**

- Саальчин, тэжээлийн технологичийн үндсэн болон нэмэгдэл цалин хөлс

**ҮНЗХ**

- Эмчилгээний зардал
- Хангамжийн материалын зардал
-Ариутгал, цэвэрлэгээний зардал
-Шатах тослох материалын зардал
-Хөдөлмөр хамгаалал
-Цахилгаан дулааны зардал
-Сэлбэг хэрэгсэлийн зардал
-Үйлдвэрийн бусад ажилчдын цалин, НДШ
-Ажилчдын хоолны зардал
-Гар утасны хэрэглээний зардал
-Үндсэн хөрөнгийн элэгдэл
-Даатгалын зардал
-Засвар үйлчилгээ
-Шинжилгээний зардал
-Урсгал засварын зардал
-Байгууллагын төлөх НДШ

**ДҮ**

-

**ББ**

**Хүснэгт 2-1 ХАА-н бүтээгдэхүүн сүүний хуримтлуулсан зардлыг бүртгэсэн байдал:**

| № | Санал болгох /НББОУС41/ | Дт | Кт | | Компанийн бүртгэл | Дт | Кт |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | ДҮ-ШХЗ | 19,752,465 | | | | | |
| | ҮНЗХ-ШБХЗ | 276,534,504 | | | ББӨ-ҮАА-Цалин,НДШ | 296,286,969 | |
| | Цалингийн тооцоо | | 296,286,969 | | Цалингийн тооцоо | | 296,286,969 |
| 2 | ҮНЗХ- ШБХЗ-Ажилчдын хоолны зардал | 45,087,295 | | | ББӨ-ҮАА-Ажилчдын хоолны зардал | 45,087,295 | |
| | Хангамжийн материал | | 45,087,295 | | Хангамжийн материал | | 45,087,295 |
| 3 | ҮНЗХ-ШБМЗ-Түлш шатахуун | 67,458,032 | | | ББӨ-ҮАА-Түлш шатахуун | 67,458,032 | |
| | Дансны өглөг\харилцах | | 67,458,032 | | Дансны өглөг\харилцах | | 67,458,032 |
| 4 | ҮНЗХ-Бусад шууд бус зардал-Гар утас | 1,887,204 | | | ББӨ-ҮАА-Гар утас | 1,887,204 | |
| | Дансны өглөг\харилцах | | 1,887,204 | | Дансны өглөг\харилцах | | 1,887,204 |
| 5 | ҮНЗХ-ШБМЗ-Бичиг хэрэг | 164,750 | | | ББӨ-ҮАА-Бичиг хэрэг | 164,750 | |
| | Хангамжийн зүйл | | 164,750 | | Хангамжийн зүйл | | 164,750 |
| 6 | ҮНЗХ-ШБХЗ- Тэтгэмж /АО-ын/ | 1,321,817 | | | ББӨ-ҮАА-Тэтгэмж /АО-ын/ | 1,321,817 | |
| | Цалингийн тооцоо | | 1,321,817 | | Цалингийн тооцоо | | 1,321,817 |
| 7 | ҮНЗХ-ШБМЗ- Хөдөлмөр хамгаалал | 6,310,573 | | | ББӨ-ҮАА-Хөдөлмөр хамгаалал | 6,310,573 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Хөдөлмөр хамгааллын хувцас | | 6,310,573 | | Хөдөлмөр хамгааллын хувцас | | 6,310,573 |
| 8 | ҮНЗХ-ШБМЗ- Дулаан | 1,140,959 | | | ББӨ-ҮАА-Дулаан | 1,140,959 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 1,140,959 | | Дансны өглөг\Харилцах | | 1,140,959 |
| 9 | ҮНЗХ-ШБМЗ- Цахилгаан | 53,279,921 | | | ББӨ-ҮАА-Цахилгаан | 53,279,921 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 53,279,921 | | Дансны өглөг\Харилцах | | 53,279,921 |
| 10 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал – Урсгал засвар | 4,815,740 | | | ББӨ-ҮАА-Урсгал засвар | 4,815,740 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 4,815,740 | | Дансны өглөг\Харилцах | | 4,815,740 |
| 11 | ҮНЗХ-ШБМЗ- Ариутгал, цэвэрлэгээ | 24,006,800 | | | ББӨ-ҮАА-Ариутгал, цэвэрлэгээ | 24,006,800 | |
| | Хангамжийн материал | | 24,006,800 | | Хангамжийн материал | | 24,006,800 |
| 12 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал - Шинжилгээ | 586,500 | | | ББӨ-ҮАА-Шинжилгээ | 586,500 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 586,500 | | Дансны өглөг\Харилцах | | 586,500 |
| 13 | ҮНЗХ-ШБМЗ- Элэгдэл | 393,146,205 | | | ББӨ-ҮАА-Элэгдэл | 393,146,205 | |
| | Хуримтлагдсан элэгдэл | | 393,146,205 | | Хуримтлагдсан элэгдэл | | 393,146,205 |
| 14 | ҮНЗХ-ШБХЗ- Гэрээт ажил | 18,046,308 | | | ББӨ-ҮАА-Гэрээт ажил | 18,046,308 | |
| | Цалин тооцоо | | 18,046,308 | | Цалин тооцоо | | 18,046,308 |
| 15 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал - Төлбөр | 9,000 | | | ББӨ-ҮАА-Төлбөр | 9,000 | |
| | Касс | | 9,000 | | Касс | | 9,000 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 16 | ҮНЗХ- ШБМЗ - Хангамжийн материалын зардал | 50,208,289 | | | ББӨ-ҮАА-ХМ зардал | 50,208,289 | |
| | Хангамжийн материал | | 50,208,289 | | Хангамжийн материал | | 50,208,289 |
| 17 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал – Утас, факс, интернэт | 9,716,923 | | | ББӨ-ҮАА-Утас,факс интернэт | 9,716,923 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 9,716,923 | | Дансны өглөг\Харилцах | | 9,716,923 |
| 18 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал – Эмчилгээ, үйлчилгээ | 15,249,481 | | | ББӨ-ҮАА-Эмчилгээ үйлчилгээ | 15,249,481 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 15,249,481 | | Дансны өглөг\Харилцах | | 15,249,481 |
| 19 | ДҮ-ШМЗ- Тэжээлийн зардал | 688,733,756 | | | | | |
| | ҮНЗХ-ШБМЗ- Тэжээлийн зардал | 373,866,650 | | | ББӨ-ҮАА-Тэжээлийн зардал | 1,062,600,406 | |
| | ТЭМ-Тэжээл | | 1,062,600,406 | | ТЭМ-Тэжээл | | 1,062,600,406 |
| 20 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал – Тээврийн зардал | 705,000 | | | ББӨ-ҮАА-Тээврийн зардал | 705,000 | |
| | Түлш шатахуун | | 705,000 | | Түлш шатахуун | | 705,000 |
| 21 | ҮНЗХ- Бусад шууд бус зардал – Засвар, үйлчилгээ - | 2,063,166 | | | ББӨ-ҮАА-Засвар, үйлчилгээ /Тээврийн хэрэгсэл/ | 2,063,166 | |
| | Дансны өглөг\Харилцах | | 2,063,166 | | Дансны өглөг\Харилцах | | 2,063,166 |
| 22 | ҮНЗХ-ШБМЗ- Сэлбэг хэрэгсэл | 13,861,971 | | | ББӨ-ҮАА-Сэлбэг хэрэгсэл | 13,861,971 | |
| | ХМ-Сэлбэг хэрэгсэл | | 13,861,971 | | ХМ-Сэлбэг хэрэгсэл | | 13,861,971 |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 23 | ҮНЗХ-ШБМЗ- Тос, тосолгоо | 3,540,654 | | | ББӨ-ҮАА-Тос, тосолгоо | 3,540,654 | |
| | ХМ-Шатах тослох материал | | 3,540,654 | | ХМ-Шатах тослох материал | | 3,540,654 |
| 24 | ҮНЗХ-ШБМЗ- Цэвэрлэгээ | 30,000 | | | ББӨ-ҮАА-Цэвэрлэгээ/Тээврийн хэрэгсэл/ | 30,000 | |
| | ХМ-Цэвэрлэгээний материал | | 30,000 | | ХМ-Цэвэрлэгээний материал | | 30,000 |
| 25 | **I. ҮНЗ-г үйлдвэрлэлд ногдуулж бүртгэх:** | | | | | | |
| | ДҮ | 1,363,037,743 | | | | | |
| | ҮНЗХ | | 1,363,037,743 | | | | |
| | **II. Өртгийн гадагш шилжүүлэлтийг бүртгэх:** | | | | | | |
| 26 | Бэлэн бүтээгдэхүүн сүү | 1,076,681,677 | | | | | |
| | Сүү хүлээн зөвшөөрөх үеийн гарз | 994,842,287 | | | | | |
| | ДҮ | | 2,071,523,964 | | | | |

## I. Үйлдвэрлэлийн зардлыг ангилж, бүртгэх:

| Анх сүү хүлээн зөвшөөрөхдөө: | Стандартаар | Компанийн бүртгэлээр | Сангийн яамнаас гаргасан журмаар |
|---|---|---|---|
| Дт ХАА-н бүт-Сүү | 1,076,681,676.60 | 1,173,031,398.60 | 1,110,516,446.50 |
| Дт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн гарз | 994,842,287.18 | | |
| Кт Дуусаагүй үйлдвэрлэл | 2,071,523,963.78 | | |
| Кт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн олз | | 1,173,031,398.60 | 1,110,516,446.50 |

Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалын хавсралтад борлуулалтын зардал гэж хөрөнгийг данснаас хасахтай шууд хамаарал бүхий өсөн нэмэгдүүлсэн зардал бөгөөд тухайн хөрөнгийг зах зээлд хүргэхэд зайлшгүй гарах тээврийн болон бусад зардал нь бодит үнэ цэнийн тооцоололд шингэсэн байдаг тул эдгээр зардлыг оруулахгүй гэжээ. Иймд сангийн яамнаас гаргасан журмаарх сүү хүлээн зөвшөөрөлтийн дүнг тооцохдоо сүүг бэлтгэн нийлүүлэгчдэд хүргэж өгөхөд гарсан түлш шатахууны /33,834,769.90/ зардлыг хасаагүй болно.

Харин НББОУС 41-д тийм зүйл дурдаагүй тул хасаж тооцсон.

**Залруулах бичилт:**

| | |
|---|---|
| Дт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн олз | 1,173,031,398.60 |
| Дт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн гарз | 994,8428287.18 |
| Кт ХАА-н бүтээгдэхүүн - Сүү | 96,349,722.00 |
| Кт Дуусаагүй үйлдвэрлэл | 2,071,523,963.78 |

| № | "Хишигтэн нүүдэлчин" ХХК | | | Санал болгох хувилбар /НББОУС 41/ | | |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ***Сүү үйлдвэрлэлтэй холбоотой зардал бүртгэх үеийн бичилт:*** | | | | | |
| | Дт ББӨ-ҮАА | 2,071,523,964 | | Дт ДҮ-Сүү | 2,071,523,964 | |
| | Кт ШМЗ | | 688,733,756 | Кт ШМЗ | | 688,733,756 |
| | Кт ШХЗ | | 19,752,465 | Кт ШХЗ | | 19,752,465 |
| | Кт ҮНЗХ | | 1,363,037,743 | Кт ҮНЗХ | | 1,363,037,743 |
| 2 | ***Сүү анх хүлээн зөвшөөрөх үеийн бичилт:*** | | | | | |
| | Дт Бэлэн бүтээгдэхүүн-Сүү | 1,173,031,399 | | Дт Бэлэн бүтээгдэхүүн-Сүү | 1,076,681,677 | |
| | Кт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн олз | | 1,173,031,399 | Дт Сүү хүлээн зөвшөөрөх үеийн гарз | 994,842,287 | |
| | | | | Кт ДҮ-Сүү | | 2,071,523,964 |
| 3 | ***Сүү борлуулах үеийн бичилт:*** | | | | | |
| | Дт ББӨ-ҮАА-Сүү | 1,173,031,399 | | Дт ББӨ-ҮАА-Сүү | 1,076,681,677 | |
| | Кт Бэлэн бүтээгдэхүүн-Сүү | | 1,173,031,399 | Кт Бэлэн бүтээгдэхүүн-Сүү | | 1,076,681,677 |
| | Дт Мөнгө/Дансны авлага | 1,135,831,520 | | Дт Мөнгө/Дансны авлага | 1,135,831,520 | |
| | Кт Борлуулалтын орлого-Сүү | | 1,135,831,520 | Кт Борлуулалтын орлого-Сүү | | 1,135,831,520 |
| | ***Цэвэр ашиг дахь нөлөө*** | | | | | |
| | Борлуулалтын орлого-Сүү | 1,135,831,520 | | Борлуулалтын орлого-Сүү | 1,135,831,520 | |
| | Сүү хүлээн зөвшөөрөх үеийн олз | 1,173,031,399 | | | | |
| | ББӨ-ҮАА | 2,071,523,964 | | ББӨ-ҮАА-Сүү | 1,076,681,677 | |
| | ББӨ-ҮАА-Сүү | 1,173,031,399 | | Сүү хүлээн зөвшөөрөх үеийн гарз | 994,842,287 | |
| | **Цэвэр нөлөө** | (935,692,444) | | **Цэвэр нөлөө** | (935,692,444) | |

## 2. Тугал болон эр үхрийн үнэ цэнийн тооцоолол

Тугал болон борлуулах зорилгоор эзэмшдэг эр өсвөр үхрийг дангаар нь арилжаалдаг идэвхтэй зах зээл байхгүй учраас амьдын жинд суурилан тооцоолсон махны борлуулах зардлыг хассан бодит үнэ цэнээр хэмжих шаардлагатай.

| № | | **Эр** | 1 настай | 2 настайгаас дээш |
|---|---|---|---|---|
| 1 | | нэгж дундаж жин | 198 | 434 |
| 2 | | Цэвэр махны жин (хувиар) | 78% | 51% |
| 3 | (1*2) | Цэвэр махны жин (кг) | 153.5 | 221.3 |
| 4 | | Махны дундаж үнэ | 8,563.70 | 8,563.70 |
| 5 | | Нийт үнэ | 1,314,094.70 | 1,895,482.00 |
| 6 | (4*6) | Тооцоолсон нэгж бодит үнэ | 1,300,000.00 | 1,900,000.00 |
| 7 | | Малын тоо | 91 | 73 |
| 8 | | Нийт дүн (нас тус бүрээр) | 118,300,000 | 138,700,000 |
| 9 | | Борлуулалтын зардал | - | - |
| 10 | | Нийт бодит үнэ цэнэ | 257,000,000.00 | |
| 11 | | **Эм** | 1 наст | 2 наст |
| 12 | | нэгж дундаж жин | 198 | 434 |
| 13 | | Цэвэр махны жин (хувиар) | 100% | 100% |
| 14 | (12*13) | Цэвэр махны жин (кг) | 198 | 434 |
| 15 | | Махны дундаж үнэ | 8564 | 8564 |
| 16 | (14*15) | Нийт үнэ | 1,695,606.00 | 3,716,631.00 |
| 17 | | Нэгж бодит үнэ цэнэ | 1700000 | 3700000 |
| 18 | | Төл малын тоо | 160 | 46 |
| 19 | (17*18) | Нийт дүн (нас тус бүрээр) | 272,000,000 | 170,200,000 |
| 20 | | Нийт эм тугалын БҮЦ | 442,200,000 | |
| 21 | (10+20) | ***Нийт тугал, эр үхрийн БҮЦ*** | **699,200,000** | |
| 22 | | ***Компанийн бүртгэлээрхи дүн*** | **451,430,000** | |
| 23 | (21-22) | ***Хүлээн зөвшөөрөх олз-Зөрүү*** | ***+247,770,000*** | |

Тус компанийн хувьд тугал болон эр үхрийн бодит үнэ цэнэд залруулга бичилт хийвэл:

| | **Стандартын бүртгэлээр** | **Компанийн бүртгэлээр** | **Залруулах бичилт** |
|---|---|---|---|
| Бараа материал- Эргэлтийн биологийн хөрөнгө | 699,200,000.00 | 451,430,000.00 | +247, 770, 000 |
| Биологийн хөрөнгийн дахин хэмжилтийн олз | 699,200,000.00 | 451,430,000.00 | +247, 770 ,000 |

Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалын хавсралт “Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан ХАА-н бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт”-д ХАА-н 41 стандартаас ялгаатай зүйл байхгүй тул стандартын бүртгэлтэй адил болно.

## 3. Сүүний үнээний бодит үнэ цэнийн тооцоолол

Үндсэн сүргийн үхрийн бодит үнэ цэнийг хэмжихдээ үхрээс ирээдүйн жил тутамд өгөх сүүнээс орох жил бүрийн цэвэр мөнгөн урсгал болон өгөөж өгөх сүүлийн жилийн үхрийн амьдын

жингийн махны гарцад суурилан тооцоолсон махны борлуулалтаас орох цэвэр мөнгөн урсгалыг өнөөгийн зах зээлийн хорогдуулах хувийг ашиглан хорогдуулж тооцох нь зүйтэй.

**Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн тооцоолол**

| | |
|---|---|
| Инфляцийн түвшин | 12% |
| ХАА-н салбарын эрсдэл | 1% |
| Бусад урамшуулал | 2% |
| Discount rate/хөнгөлөлтийн хувь/ | 15% |

*Эх үүсвэр: Өөрийн судалгааны дүнгээс*

Бизнес төлөвлөгөөнд үнээний төллөлтийн тоог бууруулж, сүүний гарцыг хамгийн багаар, зардлыг хамгийн ихээр, үхрийн хорогдлын хувийг салбарын дундажаар авч тооцоолсон.

**Сүүний чиглэлийн үхрийн бодит үнэ цэнийн тооцоолол-Үнээ**

| № | Томъёо | Төслийн жил | | 1 | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | Насжилт | | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 2 | | Он | | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
| 3 | | Саалинд хамрагдах хугацаа | хоног | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 90 |
| 4 | | Өдрийн сүүний гарц /дундаж/ | кг | | 10.6 | 17.1 | 16.1 | 16.1 | 15.1 | 14.1 |
| 5 | (3*4*14) | Сүүний гарц /жилийн/ | кг | 931,009.4 | 423,523.0 | 646,722.0 | 579,439.0 | 549,976.0 | 488,183.0 | 128,169.0 |
| 6 | | Нэгжийн үнэ | төг | 1220 | 1220 | 1220 | 1342 | 1342 | 1342 | 1342 |
| 7 | (5*6) | Борлуулалт /Сүү/ | мян төг | 1,135,832 | 516,698 | 789,001 | 777,607 | 738,068 | 655,142 | 172,003 |
| 8 | (9*10) | Борлуулалт /Мах/ | мян төг | | | | | | | 264,678.98 |
| 9 | | - Амьдын жин /кг/-ийн 51%: | кг | | | | | | | 306 |
| 10 | | Махны зах зээлийн нэгжийн үнэ: | төг | | | | | | | 8,564.00 |
| 11 | | ҮАА-н мөнгөн зардал | | 1,942,913 | 591,236 | 576,385 | 729,809 | 710,546 | 686,928 | 432,482 |
| 12 | | Элэгдлийн зардал | | 393,146 | 146,504 | 212,126 | 203,872 | 194,165 | 184,457 | 175,631 |
| 13 | 7+12-11 | ЦМУ (Цэвэр мөнгөн урсгал) | | (413,935) | 71,966 | 424,742 | 251,670 | 221,687 | 152,671 | 179,831 |
| 14 | | Үнээний тоо: | | 307 | 131 | 124 | 118 | 112 | 106 | 101 |
| 15 | | - Хорогдлын хувь | | 13 | 7 | 6 | 6 | 6 | 5 | 5 |
| 16 | 13/14 | нэгж үхэрт ногдох ЦМУ | | -1348.3 | 549.4 | 3425.3 | 2132.8 | 1979.3 | 1440.3 | 1780.5 |
| 17 | | Discount rate (Хөнгөлөлтийн хувь) | 0.15 | 1 | 0.8696 | 0.7561 | 0.6575 | 0.5718 | 0.4972 | 0.4323 |
| 18 | 16*17 | ХЦМУ | | -1348.32 | 477.72 | 2589.90 | 1402.31 | 1131.79 | 716.11 | 769.71 |
| 19 | ∑18 | Нэг сүүний үхрийн дундаж өнөөгийн үнэ | | 7087.55 | | | | | | |

**Сүүний чиглэлийн үхрийн бодит үнэ цэнийн тооцоолол-Дөнж**

| № | Томъёо | Төслийн жил | | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | Насжилт | | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 |
| 2 | | Он | | 2016 | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 |
| 3 | | Саалинд хамрагдах хугацаа | хоног | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 90 |
| 4 | | Өдрийн сүүний гарц /дундаж/ | кг | | 16.1 | 17.1 | 17.1 | 16.1 | 16.1 | 15.1 | 14.1 |
| 5 | (3*4*12) | Сүүний гарц /жилийн/ | кг | 931,009.4 | 618,723 | 625,860 | 594,567 | 530,334 | 505,782 | 451,339 | 118,017 |
| 6 | | Нэгжийн үнэ | төг | 1220 | 1220 | 1220 | 1342 | 1342 | 1342 | 1342 | 1342 |
| 7 | | Борлуулалт /Сүү/ | мян төг | 1,135,832 | 754,842 | 763,549 | 797,909 | 711,708 | 678,759 | 605,697 | 158,379 |
| 8 | | Борлуулалт мах | мян төг | | | | | | | | 243,714.31 |
| 9 | | ҮАА-н мөнгөн зардал | мян төг | 1,943,306 | 635,595 | 622,015 | 784,416 | 760,306 | 737,683 | 699,853 | 331,011 |
| 10 | | Элэгдлийн зардал | мян төг | 393,146 | 157,496 | 119,104 | 114,238 | 108,556 | 103,261 | 97,965 | 92,670 |
| 11 | (7+10-9) | ЦМУ (Цэвэр мөнгөн урсгал) | мян төг | (414,329) | 276,743 | 260,638 | 127,731 | 59,958 | 44,337 | 3,809 | 163,752 |
| 12 | | Үнээний тоо | | 307 | 126 | 120 | 114 | 108 | 103 | 98 | 93 |
| 13 | | - Хорогдлын хувь | | 13 | 6 | 6 | 6 | 5 | 5 | 5 | 5 |
| 14 | (11/12) | нэгж үхэрт ногдох ЦМУ | | -1349.6 | 2196.4 | 2172.0 | 1120.4 | 555.2 | 430.5 | 38.9 | 1760.8 |
| 15 | | Discount rate (Хөнгөлөлтийн хувь) | 0.15 | 1 | 0.86960 | 0.75610 | 0.65750 | 0.57180 | 0.49720 | 0.43230 | 0.37590 |
| 16 | (14*15) | ХЦМУ | | -1349.60 | 1909.97 | 1642.24 | 736.69 | 317.44 | 214.02 | 16.80 | 661.87 |
| 17 | ∑16 | Нэг сүүний үхрийн дундаж өнөөгийн үнэ | | 5499.04 | | | | | | | |

**Сүүний чиглэлийн үхрийн бодит үнэ цэнийн тооцоолол-Гунж**

| № | Томъёо | Төслийн жил | | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | | Насжилт | | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 |
| 2 | | Он | | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 |
| 3 | | Саалинд хамрагдах хугацаа | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 305 | 90 |
| 4 | | Өдрийн сүүний гарц /дундаж/ | | 12.6 | 16.1 | 17.1 | 17.1 | 16.1 | 16.1 | 15.1 | 14.1 |
| 5 | (3*4*13) | Сүүний гарц /жилийн/ | литр | 368,928 | 1,001,742 | 1,048,316 | 1,105,686 | 1,095,042 | 1,149,057 | 1,022,421 | 267,759 |
| 6 | | Нэгжийн үнэ | төг | 1220 | 1220 | 1342 | 1342 | 1342 | 1342 | 1342 | 1342 |
| 7 | (5*6) | Борлуулалт Сүү | мян төг | 450,092 | 1,222,125 | 1,406,839 | 1,483,831 | 1,469,546 | 1,542,034 | 1,372,089 | 359,333 |
| 8 | | Борлуулалт мах | мян төг | | | | | | | | 552,943,224 |
| 9 | | ҮАА-н мөнгөн зардал | мян төг | 414,902 | 926,212 | 1,215,242 | 1,309,520 | 1,407,587 | 1,473,474 | 1,401,597 | 664,860 |
| 10 | | Элэгдлийн зардал | мян төг | 31,718 | 75,635 | 84,317 | 98,936 | 113,190 | 126,605 | 196,195 | 186,134 |
| 11 | (7+10-9) | ЦМУ (Цэвэр мөнгөн урсгал) | мян төг | 66,908 | 371,548 | 275,914 | 273,247 | 175,148 | 195,165 | 166,687 | 433,550 |
| 12 | | Үнээний тоо | | 353 | 448 | 433 | 432 | 432 | 433 | 315 | 222 |
| 13 | | Гунжны тоо | | 96 | 204 | 201 | 212 | 223 | 234 | 222 | 211 |
| 14 | (11\13) | нэгж үхэрт ногдох ЦМУ | | 697.0 | 1821.3 | 1372.7 | 1288.9 | 785.4 | 834.0 | 750.8 | 2054.7 |
| 15 | | Discount rate (Хөнгөлөлтийн хувь) | 0.15 | 0.8696 | 0.7561 | 0.6575 | 0.5718 | 0.4972 | 0.4323 | 0.3759 | 0.3269 |
| 16 | (14*15) | ХЦМУ | | 606.08 | 1377.10 | 902.56 | 736.99 | 390.51 | 360.56 | 282.24 | 671.69 |
| 17 | ∑16 | Нэг сүүний үхрийн дундаж өнөөгийн үнэ | | 5,328 | | | | | | | |

**Биологийн хөрөнгийн бодит үнэ цэнийн залруулга**

| Эргэлтийн бус биологийн хөрөнгө | Тоо | 1 үхрийн БҮЦ | Нийт тооцсон БҮЦ |
|---|---|---|---|
| Үнээ | 131 | 7,100,000 | 930,100,000 |
| Дөнж | 126 | 5,500,000 | 693,000,000 |
| Гунж | 50 | 5,300,000 | 265,000,000 |
| ***Тооцсон БҮЦ*** | | | ***1,888,100,000*** |
| ***Бүртгэлээрх дүн*** | | | ***1,864,600,000*** |
| ***Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн олз*** | - | - | ***+23,500,000*** |

| | **Стандартын дүн /балансад/** | **Компанийн дүн /балансад/** | **Залруулах дүн** |
|---|---|---|---|
| Бараа материал- Эргэлтийн бус биологийн хөрөнгө | 1,888,100,000 | 1,864,600,000 | +23,500,000 |

**Залруулах бичилт:**

Дт Биологийн хөрөнгө-Эргэлтийн бус биологийн хөрөнгө 23,500,000

Кт Биологийн хөрөнгийн дахин үнэлгээний олз 23,500,000

4. **Тугал төрөх үеийн бодит үнэ цэнийн тооцоолол**

| | |
|---|---|
| Тугал хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийн олз-Бүртгэл | 143,400,000 |
| 0 сартай тугал | Эр , Эм |
| нэгж дундаж жин | 75 |
| Цэвэр махны жин (хувиар) | 100% |
| Цэвэр махны жин (кг) | 75 |
| Махны дундаж үнэ | 8,564 |
| Нийт үнэ | 642,278 |
| Тооцоолсон нэгж бодит үнэ | 640,000 |
| Малын тоо | 251 |
| Нийт дүн (нас тус бүрээр) | 160,640,000 |
| Борлуулалтын зардал | - |
| Борлуулах зардлыг хассан БҮЦ | 160,640,000 |
| Хүлээн зөвшөөрөх олз-Зөрүү | + 17,240,000 |

| | **Стандартаар** | **Компанийн бүртгэлээр** | **Залруулах бичилт:** |
|---|---|---|---|
| Дт Бараа материал-Эргэлтийн биологийн хөрөнгө/тугал/ | 160,640,000 | 143,400,000 | 17,240,000 |
| Кт Тугал хүлээн зөвшөөрөх үеийн олз | 160,640,000 | 143,400,000 | 17,240,000 |

5. **Эм бяруug гунжруу нас дэвшүүлэх бүртгэл**

| | Тоо | Нэгжийн үнэ | Нийт үнэ |
|---|---|---|---|
| Бярууны бүртгэлээрх дүн | 15 | 3,500,000 | 52,500,000 |
| Гунжны бодит үнэ цэнэ | 15 | 5,300,000 | 79,500,000 |
| ***Бүртгэлээрх нас дэвшилтийн олз*** | ***8,600,000*** | | |
| ***Тооцоолсон Нас дэвшилтийн олз*** | ***27,000,000*** | | |
| ***Зөрүү- Бодит үнэ цэнийн өсөлт*** | ***+ 18,400,000*** | | |

| | **Стандартаар** | **Компанийн бүртгэлээр** | **Залруулах бичилт** |
|---|---|---|---|
| Дт Биологийн хөрөнгө-Эргэлтийн бус биологийн хөрөнгө | 79,500,000 | 61,100,000 | 18,400,000 |
| Кт Үхэр сүргийн нас дэвшилтийн олз | 27,000,000 | 52,500,000 | 18,400,000 |
| Кт Бараа материал-Эргэлтийн биологийн хөрөнгө | 52,500,000 | 8,600,000 | - |

**“Хишигтэн нүүдэлчин” ХХК**

**Орлого үр дүнгийн тайлан**

| **№** | **Дансны нэр** | **ААН-ийн бүртгэлээр** | **Стандартаар** | **Зөрүү** |
|---|---|---|---|---|
| **1** | **Борлуулалтын орлого /цэвэр/** | **1,334,140,071** | **1,334,140,071** | **-** |
| **2** | **Борлуулалтын өртөг** | **(3,601,188,074)** | **(1,433,314,389)** | **2,167,873,685** |
| **3** | **Нийт ашиг (алдагдал)** | **(2,267,048,003)** | **(99,174,318)** | **2,167,873,685** |
| **4** | **Бусад орлого** | **1,338,013,805** | **(523,019,881)** | **(1,861,033,686)** |
| | Сүү анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүсэн бодит үнэ цэний олз (гарз) | 1,173,031,399 | (994,842,287) | **(2,167,873,686)** |
| | Тугал анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүсэн бодит үнэ цэний олз (гарз) | 143,400,000 | 160,640,000 | **17,240,000** |
| | Үхэр сүргийн нас дэвшилтийн олз, гарз /гунж/ | 8,600,000 | 27,000,000 | **18,400,000** |
| | Биологийн хөрөнгийн дахин хэмжилтээс үүссэн бодит үнэ цэнийн олз | - | 271,200,000 | **271,200,000** |
| | Туслах үйл ажиллагааны орлого | 5,343,505 | 5,343,505 | **-** |
| | Үйл ажиллагааны бус бусад орлого | 7,638,901 | 7,638,901 | **-** |
| **5** | **Борлуулалт, маркетингийн зардал** | **(44,311,052)** | **(44,311,052)** | **-** |
| **6** | **Ерөнхий ба удирдлагын зардал** | **(492,660,546)** | **(492,660,546)** | **-** |
| **7** | **Санхүүгийн зардал** | **(215,726,357)** | **(215,726,357)** | **-** |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **8** | **Бусад зардал** | **(71,205,766)** | **(71,205,766)** | **-** |
| **9** | **Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)** | **(64,178,319)** | **(64,178,319)** | **-** |
| **10** | **Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)** | **(57,940,930)** | **(57,940,930)** | **-** |
| **11** | **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **(1,875,057,168)** | **(1,568,217,169)** | **306,839,999** |
| **12** | **Татварын дараах ашиг (алдагдал)** | **(1,875,057,168)** | **(1,568,217,169)** | **306,839,999** |

## ДҮГНЭЛТ, САНАЛ

***Дүгнэлт:***

- Практик боломжгүй байгаагаас бусад нөхцөлд ХАА-н үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа биологийн хөрөнгө болох мал амьтан, түүнээс хүлээн авсан ХАА-н бүтээгдэхүүнийг бодит үнэ цэн буюу зах зээлийн үнэ ханшаар тайланд илэрхийлэхийг шаардаж байгаа ХАА-н үйл ажиллагааны бүртгэлийн гол зарчим болж байна.

Энэ нь төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн буюу хуучин нэгдэл, сангийн аж ахуйн төлөвлөгөөт үнээр бүртгэлд тусгах аргазүйн үндсэн зарчим дээр суурилсан сайжруулсан хувилбар ажээ.

- ХАА-н үйл ажиллагаа эрхлэгч ААН-үүдээс авсан судалгааны үр дүнг харвал СТОУС-ын дагуу бүртгэл хийж чадахгүй байгаа бөгөөд гол шалтгаан нь бодит үнэ цэнийг тодорхойлоход хүндрэлтэй байна гэжээ. Өөрөөр хэлбэл ААН-үүд өртөгт суурилсан бүртгэлийг хийсээр байна.
- Судалгааны объект болох "Хишигтэн нүүдэлчин" ХХК-ийн хувьд СТОУС-ын дагуу бүртгэл хийхийг оролдож, түүнд нийцүүлэхийг хичээж байгаа боловч бодит үнэ цэнийг холбогдох стандартын дагуу ул үндэслэлтэй, найдвартай тооцоолж чадахгүй байна.

Мөн сүүний аж ахуй дээр гарч байгаа бүхий л зардлыг тайлант үеийн борлуулсан бүтээгдэхүүний өртгөөр тайлагнаж байгаа нь бүтээгдэхүүний түүхэн өртгийн мэдээллийг тодорхойгүй болгож, өртөг хуримтлуулан бүртгэх үндсэн суурь арга аргачлалыг хэрэглэх боломжгүй болгож байна. Өөрөөр хэлбэл сүү үйлдвэрлэлийн үйл ажиллагааны НББ-ийн зохион байгуулалт, мэдээллийн систем эмх цэгцгүй, тодорхойгүй байна.

- СТОУС-ын дагуу уг компанийн бүртгэлийг хийж үзэхэд тугал анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүсэн бодит үнэ цэнийн олз 17,240,000₮-өөр өсч, бяруу гунжруу нас дэвшилтийн олз 18,400,000₮-өөр өсч, үндсэн сүргийн мал амьтан саалийн үнээний бодит үнэ цэнэ 247,700,000 ₮-өөр өсч, харин биологийн хөрөнгөөс хүлээн авсан ХАА-н бүтээгдэхүүн болох сүү хүлээн зөвшөөрөлтийн гарз 994,842,287₮ болсоноор 2016 оны алдагдал 306,839,999 ₮-өөр өсч байна.

***Санал:***

- Биологийн хөрөнгө бусад хөрөнгөнөөс маш их ялгаа, онцлогтой учраас тэдгээрийг бодит үнэ цэнээр илэрхийлэх нь ХАА-н ААН-үүдийн хөрвөх чадварыг бодитой харуулах гол нөхцөл учраас бодит үнэ цэнийг хэрхэн тооцох, тодорхойлох талаар тусгайлсан гарын авлага, заавар, зөвлөмж, холбогдох сургалт судалгаа хийх шаардлагатай байна.
- ХАА-н үйлдвэрлэл, үйл ажиллагаатай холбоотой өртөг ба зардлыг хэрхэн тооцож, бүртгэх, түүнийгээ СТОУС-аар шаардсан бодит үнэ цэнээр тайлагнах шаардлагуудтай хэрхэн уялдуулж нийцүүлэх талаар аргазүй боловсруулах хэрэгтэй байна.

- ХАА-н үйл ажиллагааны төрөл бүрт тохирсон биологийн хөрөнгө болон ХАА-н бүтээгдэхүүний бүртгэлд шаардлагатай тохирох дансуудын тогтсон нэршил буюу тусгайлсан дансны төлөвлөгөөг нарийн ангилж, тодорхойлох шаардлагатай байна.

# АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ


***Ном, зохиол***

1. Я.Шагдар, Ж.Аюурзана, 1982 он, “Хөдөө аж ахуйн нэгдлийн нягтлан бодох бүртгэл”
2. Р.Батжаргал, Н.Самданжамц, 1985 он, “Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл”
3. О.Чойжилсүрэн, Р.Батжаргал, Н.Самданжамц, 1990 он, “Хөдөө аж ахуйн нягтлан бодох бүртгэл”
4. Ж.Галсансанжаа, Б.Лувсандорж, С.Гүнсмаа, Б.Барчин, 1990 он, “Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн нягтлан бодох бүртгэл”
5. ММНБИ, 2014 он, СТОУС “Хэрэглээний тайлбар”
6. ММНБИ, 2016 он, Санхүүгийн тайлагнал-1,
7. НББОУСЗ , 2016 он, НББОУС 41-“Хөдөө аж ахуй”
8. PwC, 2015, Depth in Agricultural accounting,

***Эрдэм шинжилгээний хурлын илтгэл, эмхэтгэл***

1. С. Алтанцэцэг, 2010 , “МАА-н бүтээгдэхүүний өртөг тооцох арга зүйн асуудалд”
2. С. Алтанцэцэг, 2016 , “Мал аж ахуйн нягтлан бодох бүртгэлийн онцлог асуудал”
3. С.Баярхүү, С.Оюунчимэг, 2016 , “Биологийн хөрөнгө ба хүлээн авалтын үеийн ХАА-н бүтээгдэхүүний бүртгэл, тайлагналын онцлог”
4. С. Баярхүү, 2016 , “ХАА-н үйл ажиллагаатай холбоотой НББОУС-ууд”
5. Э.Вандандулам, 2015, Д.Отгонбаяр, “Эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн өртөг тооцолт болон бүртгэлийн зарим асуудлууд”
6. Г.Лхагвадулам, 2016, “Биологийн хөрөнгө ба мал аж ахуйн бүтээгдэхүүний бүртгэл, тайлагналын асуудал”
7. Сангийн яам, 2016, Сангийн сайдын 2016 оны 411 тоот тушаалын 1 дүгээр хавсралт, Биологийн хөрөнгө ба түүнээс хүлээн авсан хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн стандарт
8. A practical guide to account for agricultural assets, 2009
9. “Evaluation of Biological Assets: Problems and Solutions”- Paper , 2013

***Электрон эх үүсвэр***

- https://www.mof.gov.mn/
- www.1212.mn
- http://investmongolia.gov.mn/
- http://web.worldbank.org/
- www.davidpublishing.com